БАТЛАВ: ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Б.ЭРХЭМЗАЯА

АЖЛЫН БАЙРНЫ ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

ЗОРИЛГО:

Ажлын байран дахь эрүүл мэндийн эрсдэлийг тандах, эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хийлгэх.

ҮНДЭСЛЭЛ:

Хууль эрх зүйн шаардлага	- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд "Ажил олгогч (28.1.4.) ажлын байранд учирч болзошгүй аюулыг илрүүлэх, тогтоох, үнэлэх, бууруулах, арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээ, (28.1.5.) ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх"; - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.1-т "Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж байгууллагын захирал, **ажил олгогч** шууд хариуцна", 31.2-т зааснаар ажлын байр шинээр бий болгох, тухайн ажлын байрны чиглэл, нөхцөл өөрчлөгдөх бүрт, химийн хорт болон аюултай бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол **жилд нэгээс доошгүй удаа** ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх; - Эрүүл ахуйн тухай хуулийн 13.1.5-д хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг үйл ажиллагааны бүх шатанд бүрэн хангах, 13.1.7-д халдварт болон халдварт бус өвчин, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх гэж тус тус заасан байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ: Компанийн төв удирдлага болон 5 салбар

Д/д	Хэлтэс, алба	Албан тушаал
1	Засварын алба	Дэд станцын засварын инженер, мастер, монтёр
2		Агаарын шугамын засварын инженер, мастер, монтёр
3	Ашиглалтын алба	Дэд станцын ашиглалтын инженер, ээлжийн инженер, ээлжийн монтёр
4		Өндөр үелзлэлийн холбооны инженер, монтёр
5		Ээлжийн диспетчер инженер
6	Реле хамгаалалт, автоматик, хэмжилт,	Хэлтэс, албаны реле хамгаалалт автоматик, HMI системийн засвар тохируулга, хэмжүүр, тоолуурын инженер, монтёр

7	туршилтын хэлтэс/алба	Өндөр хүчдэлийн туршилт, хэмжилтийн инженер, техникч, монтёр
8	Засвар зохицуулалтын хэлтэс	Шугамын засварын инженер, Хүчний трансформаторын засварын инженер, Дэд станцын засварын инженер, ПХБ-н төслийн инженер, Тосны химийн лабораторын эрхлэгч, Чанарын менежер, Лаборант, Гагнуурчин, Засварын монтёр
9	Тээвэр механизмын хэлтэс	АГП, Вышка, краны оператор, туршилтын лабораторийн жолооч
10	Хангамж үйлчилгээний хэлтэс	Ахлах тогооч, тогооч, Сантехникийн бохирын слесарь, ариун цэврийн өрөөний үйлчлэгч
11	Мэдээллийн технологийн хэлтэс	Өндөр үелзлэлийн холбооны инженер, Мэдээллийн сүлжээний инженер, Компьютерийн ашиглалтын инженер, Програмист инженер
12	Хяналт мониторингийн хэлтэс	Хэлтэс, салбарын ХАБЭА-н инженер, техникийн хяналтын инженер
13	Захиргаа удирдлагын хэлтэс	Архивын ажилтан

ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦӨЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ:

Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт хийх	- Ажлын байрны бичил цаг уур: Температур, харьцангуй чийглэг, агаарын урсгалын хурд - Физикийн хүчин зүйл: Гэрэлтүүлэг, шуугиан, доргион, цахилгаан соронзон орон, радио давтамж - Химийн хүчин зүйлс - Биеийн хүчний ачаалал - Мэдрэл сэтгэхгүйн ачаалал - Эргономикийн үнэлгээ - Хөдөлмөрийн чадвар түр алдах өвчлөлийн судалгаа
Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлан бичих	- Үнэлгээний дүгнэлт, тайланг гаргаж танилцуулах уулзалт хийх - Үр дүн, дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлж болохуйц зөвлөмж боловсруулж өгөх.

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА:

Хууль, эрх зүйн баримт бичиг	Шаардлагын төрөл, агуулга
4.1. Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхэд баримтлах хууль, эрх зүйн	- 2017 оны 12 сард батлагдаж, 2018 он 7 сарын 1-ээс эхлэн хэрэгжиж байгаа "Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай" хуулийн 15.4 дүгээр заалтын шаардлагыг хангасан байх. - MNS5080:2001 стандартын Хэвийн, Хэвийн бус нөхцөлийн ангиллын дагуу НХХСайдын 2004 оны 77 дугаар тушаал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны тогтоолоор батлагдсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх аргачилсан зөвлөмж"-ийн дагуу хийж гүйцэтгэх.

баримт, удирдамж, аргачлал	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний багцыг тодорхойлоход 2014 оны Эрүүл мэндийн сайдын 340 дүгээр тушаалыг үндэслэл болгох.

ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Шаардлага	- MNS ISO/IEC 17020:2013 стандартаар итгэмжлэгдсэн байх; - Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага байх; - Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийж байсан туршлагатай байх; - Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний хүрээнд шинжилгээ хийлгэх лаборатори нь MNS ISO/IEC17025 стандартаар итгэмжлэгдсэн байх; - Мэргэжлийн туршлагатай, чадварлаг шинжээчдийн бүрэлдэхүүнтэй байх; - Хэмжилтэд ашиглах багаж, тоног төхөөрөмж нь сертификаттай, баталгаажилт, тохиргоотой байх ба багажийн тоо, ширхэг хүрэлцээтэй байх; - Багаж нь хувь хүний температур, шуугиан, тоосны өртөлтийг хэмждэг байх; - Цахилгаан соронзон орны цацраг хэмжигч багажтай байх - Радио долгионы цахилгаан оронгийн хүчлэгийн хэмжих багажтай байх; - Ерөнхий болон гарт дамжих доргионыг үнэлэх багажтай байх; - Ажил гүйцэтгэх нарийвчилсан төлөвлөгөө гаргасан байх. - Мэргэшсэн хөдөлмөрийн эрүүл ахуйч эмчтэй байх.

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ:

- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ, эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний тайлан гаргана.
- Эрүүл мэндийн ноцтой, өндөр эрсдэлтэй ажлын байранд ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах инженер технологи, удирдлага зохион байгуулалт, хувьд чиглсэн урьдчилан сэргийлэлтийн арга хэмжээг ажил олгогчид зөвлөнө.
- Эрүүл мэндийн дунд зэргийн эрсдэлтэй ажлын байранд эрсдэлийн түвшинг нэмэгдүүлэхгүй байхад чиглэсэн хөдөлмөрийн эрүүл ахуйн урьдчилан сэргийлэлтийн ерөнхий арга хэмжээг ажил олгогчид зөвлөнө.
- Эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх, эрэмбэлнэ.

ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: 2 сар

ХЯНАСАН:
ХМХ-ИЙН ДАРГА Д.МӨНХЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:
ХМХ-ИЙН ХАБЭА-Н ИНЖЕНЕР Б.БАТЧУЛУУН